

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2013 оны ... сарын ... өдөр

Улаанбаатар хот

ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь Монгол Улсад газрын тос, байгалийн хий, ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмалын салбарт олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хэрэгжүүлэхтэй холбогдсон дараахь харилцааг зохицуулахад оршино. Үүнд:

1.1.1. олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хэрэгжүүлэх, байгалийн баялаг ашигласны төлбөр төрийн байгууллагад төлөгдсөн эсэхийг баталгаажуулах, түүнд хяналт тавих;

1.1.2. байгалийн баялагийг зүй зохистой ашиглахтай холбоотойгоор тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаа, олборлолтын үе шат болон төрийн байгууллага, олборлогч компани, иргэний нийгмийн эвсэл хоорондын мэдээлэл солилцох, тайлагнах ажиллагаанд дүн шинжилгээ хийх, үнэлгээ хийх зэрэгт иргэний нийгмийн оролцоог бүрэн, хараат бус, үр дүнтэй хангах явдлыг баталгаажуулах;

1.1.3. олон нийтийн ая тух, Засгийн газрын үйл ажиллагаа болон бизнесын орчинд ил тод байдал, хариуцлагын стандартыг олон улсын түвшинд хүргэх явдлыг дэмжих;

1.1.4. байгалийн баялагийг иргэн бүрт үр өгөөжтэй, үндэсний хөгжлийн эрх ашгийн дагуу зүй зохистой ашиглах боломжийг баталгаажуулах;

1.1.5. иргэдийн оролцоотой төсвийн орлого, хариуцлагын тогтолцоог сайжруулах;

1.1.6. төрийн байгууллагын орлого зарлагын талаарх олон нийтийн мэдлэг мэдээллийг сайжруулах, улмаар олон нийтийн хэлэлцүүлгийг дэмжих, тогтвортой хөгжлийн төлөөх зохистой, ухамсартай сонголт хийхэд шаардлагатай мэдээллээр хангах;

1.1.7. ил тод байдлыг нэмэгдүүлэх замаар гадаад дотоодын хөрөнгө оруулалтын орчинг сайжруулах;

1.1.8. энэ зүйлд заасан бусад асуудлын ашиг тусын талаар олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хэрэгжүүлэх Үндэсний зөвлөлийн бүх оролцогч талуудад мэдээлж, дэмжлэг авах.

1.2. Энэ хуулийн дагуу шийдвэр гаргах эрх бүхий этгээд нь дээрх зорилгод нийцүүлэн аливаа шийдвэрийг гаргаж байх ёстой.

2 дугаар зүйл. Хууль тогтоомж

2.1. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль¹, Газрын хэвлийн тухай хууль², Газрын тосны тухай хууль³, Ашигт малтмалын тухай хууль⁴, Цөмийн энергийн тухай хууль⁵ болон энэ хууль, эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

3.1. Энэ хуулиар Монгол Улсад газрын тос, байгалийн хий, ашигт малтмал, цөмийн энергийн ашигт малтмалын салбарын хүрээнд олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Засгийн газрын тайлан гаргагч, олборлогч компаниаас тайлан гаргах, аудитын шинжилгээ хийх, аж ахуйн нэгж, Засгийн газрын тайлан гаргагчийн гаргасан тайланд зөрүү гарвал түүнийг шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

4 дүгээр зүйл. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын үйл ажиллагаанд баримтлах зарчим

4.1. Монгол Улсад олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хэрэгжүүлэхэд оролцогч талуудын адил тэгш хамтын ажиллагааны зарчим дээр үндэслэн хэрэгжүүлнэ.

4.2. Оролцогч талууд бие биеэ харилцан хүндэтгэх зарчмыг баримтална.

5 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

5.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

5.1.1. “байгалийн баялаг” гэж газрын тос, байгалийн хий, ашигт малтмал, цөмийн энергийн ашигт малтмалыг;

¹ Үндсэн хууль – “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн

² Газрын хэвлийн тухай хууль – Хууль, зарлиг, тогтоолын эмхтгэлийн 1988 оны 11 дүгээрт нийтлэгдсэн

³ Газрын тосны тухай хууль- “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1991 оны 2 дугаарт нийтлэгдсэн

⁴ Ашигт малтмалын тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2006 оны 30 дугаарт нийтлэгдсэн

⁵ Цөмийн энергийн тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2009 оны ... дугаарт нийтлэгдсэн

5.1.2. “төлбөр” гэж төрийн байгууллагад олборлогч компаниас төлсөн татвар, нийгмийн даатгалын шимтгэл, тусгай зөвшөөрлийн төлбөр, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, төрийн байгууллагад хуваариласан ногдол ашиг, торгууль, алданги, хандив, дэд бүтэц, бараа, ажил үйлчилгээнд зориулан төлсөн төлбөр, мөн олборлогч компаниас төрийн байгууллагын албан тушаалтан, эсвэл түүний зааврын дагуу гуравдагч этгээдэд төлсөн төлбөрийг,

5.1.3. “орлого” гэж төрийн байгууллага олборлогч компаниас хүлээн авсан татвар, нийгмийн даатгалын шимтгэл, тусгай зөвшөөрлийн төлбөр, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, төрийн байгууллагад хуваариласан ногдол ашиг, торгууль, алданги, хандив, дэд бүтэц, бараа, ажил үйлчилгээнд зориулан хүлээн авсан орлого, мөн олборлогч компаниас төрийн байгууллагын албан тушаалтан, эсвэл түүний зааврын дагуу гуравдагч этгээдэд оруулсан орлогыг;

5.1.4. “тайлангийн маягт” энэ хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасны дагуу Үндэсний статистикийн хорооноос батлагдсан баримт бичгийг;

5.1.5. “нэгдсэн дэлгэрэнгүй тайлан” гэж энэ хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсэгт заасан тайланг;

5.1.6. “зөрүү” гэж Засгийн газрын тайлан гаргагч, олборлогч компаниас гаргасан тайлангуудад мэдээлсэн мэдээлэл нь олборлогчоос төлсөн төлбөр, төрийн байгууллагын төвлөрүүлсэн орлого нь өөр хоорондоо зөрсөн мэдээллийг;

5.1.7. “нэгтгэгч” гэж энэ хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт заасны дагуу сонгон шалгарсан этгээдийг;

5.1.8. “тусгай зөвшөөрөл” гэж байгалийн баялагийг хайх, ашиглах, олборлох харилцааг зохицуулсан холбогдох хуулийн дагуу эрх олгосон баримт бичгийг ойлгох ба үүнд дараах баримт бичгүүд орно:

а/ Ашигт малтмалын тухай хуулийн дагуу олгосон ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл;

б/ Цөмийн энергийн тухай хуулийн дагуу олгосон цацраг идэвхт ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл;

в/ Газрын тосны тухай хуулийн дагуу байгуулсан газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээ.

5.1.9. “Ерөнхийлөгч” гэж Монгол Улсын Ерөнхийлөгчийг;

5.1.10. “Ерөнхий сайд” гэж Монгол Улсын Ерөнхий Сайдыг;

5.1.11. “Засгийн газар” гэж Монгол улсын Засгийн газрыг;

5.1.12. “Яам” гэж уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагийг;

5.1.13. “төрийн нарийн бичгийн дарга” гэж уул уурхайн асуудал эрхэлсэн яамны төрийн нарийн бичгийн даргыг;

5.1.14. “төрийн байгууллага” гэж Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, яам, тэдгээрийн харъяа байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага, бүх шатны засаг даргыг;

5.1.15. “Засгийн газрын тайлан гаргагч” гэж төрийн байгууллагад олборлогч компаниас энэ хуулийн дагуу төлсөн орлогыг тайлангийн маягтаар ажлын албанд тайлагнах үүрэг бүхий бүх шатны төрийн байгууллагыг;

5.1.16. “олборлогч компани” гэж төрийн өмчийн оролцоотой болон төрийн өмчийн оролцоогүй тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжийг;

5.1.17. “нөлөө бүхий хувьцаа эзэмшигч” гэж олборлогч компанийн хувьцааны 10-аас дээш хувийг дангаар буюу бусад этгээдтэй хамтран эзэмшиж буй этгээдийг;

5.1.18. “иргэний нийгмийн эвсэл” гэж төрийн байгууллага болон олборлогч компаниудаас хараат бус, бие даасан байдлаар ажиллах олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах чиглэлээр эвлэлдэн нэгдсэн иргэний нийгмийн эвсэл болон байгаль орчныг хамгаалах иргэний эвслийг;

5.1.19. “Үндэсний зөвлөл” гэж Монгол Улсын олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хэрэгжүүлэх олон талын оролцоог хангасан дээд байгууллагыг;

5.1.20. “ажлын хэсэг” гэж Монгол Улсын олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хэрэгжүүлэх эрх, үүрэг бүхий олон талын оролцоог хангасан төрийн байгууллага, олборлогч компани, иргэний нийгмийн эвслийн төлөөлөл бүхий зөвлөлдөх байгууллагыг;

5.1.21. “ажлын алба” гэж энэ хуулийн олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хэрэгжүүлэх ажлын албыг;

5.1.22. “ажлын албаны цахим хуудас” гэж нэгдсэн дэлгэрэнгүй тайлан болон олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хэрэгжүүлэхтэй холбоотой бусад мэдээллийг олон нийтэд ил болгох зорилгоор ажлын албанаас бүтээсэн цахим хуудсыг;

5.1.23. “оролцогч тал” гэж олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хэрэгжүүлэх эрх, үүрэг бүхий төрийн байгууллага, олборлогч компани, олборлогч компанитай гэрээ байгуулан ажиллаж байгаа туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгж, санхүүгийн байгууллага, хөрөнгө оруулагч, төрийн бус байгууллага, иргэний нийгмийн эвсэл, мэргэжлийн холбоо болон хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөллийг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ТАЙЛАГНАХ, ТАЙЛАНГ НЭГТГЭХ

6 дугаар зүйл. Тайлангийн маягт

6.1. Үндэсний статистикийн хорооноос олборлогч компани болон Засгийн газрын тайлан гаргагчийн зүгээс тусгай зөвшөөрөл бүрийн төлбөрийн төлөлт, олборлогч компанийн олборлосон, борлуулсан, экспортлосон бүтээгдэхүүний тоо хэмжээ, төрийн байгууллагад олборлогч компаниас төвлөрүүлсэн татвар, нийгмийн даатгалын шимтгэл, үйлчилгээний төлбөр, төрийн байгууллагад хуваарилсан ногдол ашиг, торгууль, алданги, хандив, туслалцаа зэрэг орлого, төлбөрийг мэдээлэх тайлангийн маягт болон нэгдсэн дэлгэрэнгүй тайлангийн маягыг батална.

7 дугаар зүйл. Олборлогч компанийн тайлан

7.1. Олборлогч компани нь тухайн жилд төрийн байгууллагад төлсөн нийт төлбөрийн талаархи дэлгэрэнгүй тайланг Үндэсний статистикийн хорооноос баталсан тайлангийн маягтаар гаргаж дараа оны 3 сарын 01-ний дотор ажлын албанд хүргүүлнэ. Тухайн тайлангийн жилд олборлогч компани үйл ажиллагаа явуулаагүй, төрийн байгууллагад ямар нэгэн төлбөр төлөөгүй байсан ч гэсэн энэ хэсэгт заасны дагуу тайланг ажлын албанд хүргүүлэх үүрэгтэй.

7.2. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэг, Байгууллагын нууцын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дох хэсэгт тус тус зааснаар төрийн байгууллагад төлсөн төлбөрийн тухай мэдээллийг олборлогч компанийн нууцад хамруулсан, эсхүл төрийн байгууллагатай байгуулсан гэрээний дагуу төлбөрийн талаархи мэдээллийг нууцлах үүрэг хүлээсэн эсэхийг үл харгалзан олборлогч компани тухайн жилд төрийн байгууллагад төлсөн төлбөрийн талаархи мэдээллийг тайлангийн маягтад заавал тусгана.

7.3. Олборлогч компани ажлын албанд хүргүүлсэн тайлангийн үнэн зөвийг өөрөө бүрэн хариуцах бөгөөд уг тайланд санаатайгаар худал мэдээлэл оруулан буруу тайлагнасан бол энэ хууль болон холбогдох бусад хуульд заасны дагуу хариуцлага хүлээнэ.

7.4. Олборлогч компанийн тайлангийн маягтаар ажлын албанд хүргүүлсэн мэдээлэл нь олборлогч компанийн тухайн жилийн санхүүгийн тайланд олон улсын стандартын дагуу хийгдсэн санхүүгийн хөндлөнгийн аудитын тайлангаар баталгаажсан мэдээлэл дээр үндэслэгдсэн байна.

8 дугаар зүйл. Засгийн газрын тайлан гаргагчийн тайлан

8.1. Засгийн газрын тайлан гаргагч нь тухайн жилд олборлогч компаниудаас төрийн байгууллагын хүлээн авсан нийт орлогын талаархи дэлгэрэнгүй тайланг Үндэсний статистикийн хорооноос баталсан тайлангийн маягтаар гаргаж дараа оны 3 сарын 25-ний дотор ажлын албанд хүргүүлнэ.

8.2. Засгийн газрын тайлан гаргагч ажлын албанд хүргүүлсэн тайлангийн үнэн зөвийг өөрөө бүрэн хариуцах бөгөөд уг тайланд санаатайгаар худал мэдээлэл оруулан буруу тайлагнасан бол тус Засгийн газрын тайлан гаргагчийн дарга, тайланг нэгтгэн бэлтгэсэн албан тушаалтан энэ хуульд заасны дагуу хариуцлага хүлээнэ.

8.3. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль, олборлогч компанитай байгуулсан гэрээний дагуу орлогын талаархи мэдээлэл нь олборлогч компанийн нууцад хамаарах, эсхүл гэрээний үүргийн дагуу орлогын талаархи мэдээллийг нууцлах үүрэг хүлээсэн эсэхийг үл харгалзан Засгийн газрын тайлан гаргагч нь Төрийн нууцын тухай хуулиар нууцласнаас бусад бүх орлогын тухай мэдээллийг тайлангийн маягтад заавал тусгана.

8.5. Засгийн газрын тайлан гаргагчийн тайлангийн маягтаар ажлын албанд хүргүүлсэн мэдээлэл нь төрийн байгууллагын тухайн жилийн санхүүгийн тайланд олон улсын стандартын дагуу хийгдсэн санхүүгийн хөндлөнгийн аудитын тайлангаар баталгаажсан мэдээлэл дээр үндэслэгдсэн байна.????

9 дүгээр зүйл. Нэгдсэн дэлгэрэнгүй тайлан

9.1. Үндэсний зөвлөл нь ажлын хэсэгтэй зөвшилцсөний дагуу нягтлан бодох бүртгэлийн мэргэжлээр их, дээд сургуулийг бакалавр буюу түүнээс дээш зэрэглэлээр төгссөн, мэргэжлээрээ 10 доошгүй жил ажилласан Монгол Улсын иргэн, эсхүл нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр 5-аас доошгүй жил үйл ажиллагаа явуулж буй мэргэжлийн хуулийн этгээдээр Засгийн газрын тайлан гаргагч, олборлогч компаниас ирүүлсэн тайланг нэгтгэх ажлыг гүйцэтгүүлнэ.

9.2. Ажлын алба нь нэгтгэгчид Засгийн газрын тайлан гаргагч, олборлогч компаниас ирүүлсэн орлого, төлбөрийн талаархи тайлангуудыг нэн даруй хүргүүлнэ. Нэгтгэгч нь олборлогч компаниас тайлангийн маягтаар ирүүлсэн тухайн жилд төлсөн нийт төлбөр, Засгийн газрын тайлан гаргагчаас тайлангийн маягтаар ирүүлсэн тухайн жилд олборлогч компаниас төрийн байгууллагын хүлээн авсан нийт орлогыг олон улсын аудитын стандартын дагуу жил бүрийн **3 сарын 1-нээс 6 сарын 30-ны дотор** нэгтгэн нэгдсэн дэлгэрэнгүй тайланг ажлын албанд хүргүүлнэ.

9.3. Нэгтгэгч нь олборлогч компани эсвэл Засгийн газрын тайлан гаргагчаас төлбөр болон орлогын талаархи тодруулга, нэмэлт мэдээллийг шаардан гаргуулах эрхтэй.

9.4. Нэгтгэгч нь нэгдсэн дэлгэрэнгүй тайланд дараах мэдээллийг тусгана:

9.4.1. **ажлын хэсэгтэй** тохиролцсон төлбөр, орлогын тодорхойлолтыг Монгол улсын хэмжээнд болон олборлогч компани бүрээр тодорхой илэрхийлнэ;

9.4.2. олборлох үйлдвэрлэлийн салбараас Монгол улсын эдийн засагт оруулж буй хувь нэмэр;

9.4.3. тайланд багтсан орлого, ашгийн урсгалуудыг тодорхойлон бичнэ;

9.4.4. олборлох үйлдвэрлэлийн салбарт эзэлж буй төрийн эзэмшлийн хувь хэмжээ;

9.4.5. олборлох үйлдвэрлэлийн салбараас орж ирсэн орлогын хуваарилалт, орлогын тогтвортой байдлын тухай;

9.4.6. орлогын урсгал тус бүрийг төрийн байгууллагын тухайн түвшинд хуримтлагдах орлогын хэмжээтэй харьцуулан нэгтгэнэ;

9.4.7. олборлогч компани бүрийн эзэмшиж буй тусгай зөвшөөрлийн жагсаалтыг гаргах ба жагсаалтын эх үүсвэрийг заана;

9.4.8. олборлогч компани бүрийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийг жагсаалтаар гаргана;

9.4.9. тайлангийн хугацаанд олборлогч компанийн явуулсан үйл ажиллагааг тусгах (хайгуулын ажил, техник эдийн засгийн үнэлгээ, олборлолт, барилга байгууламж, олборлосон, борлуулсан, экспортлосон бүтээгдэхүүний тоо хэмжээ гэх мэт) ба хэрэв олборлолт явуулсан бол олборлосон байгалийн баялаг, борлуулсан бүтээгдэхүүний хэмжээг жагсаалтаар гаргана;

9.4.10. олборлогч компанийн тусгай зөвшөөрөл олгохыг хүссэн хүсэлт, уг тусгай зөвшөөрлийг олгосон огноо, тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа болон тусгай зөвшөөрөлтэй талбайн кординатыг жагсаалтаар гаргана;

9.4.11. олборлогч компани, төрийн байгууллага хооронд байгуулагдсан бүх гэрээг жагсаалтаар гаргана;

9.4.12. олборлогч компани тайланд буруу мэдээлэл оруулсан, төлбөрийн талаар дутуу мэдээлсэн, эсхүл тайланг хуульд заасан хугацааны дотор тайлагнаагүй бол олборлогч компани энэхүү зөрчлийг яагаад гаргасан талаархи тодорхой мэдээллийг тусгана;

9.4.13. Засгийн газрын тайлан гаргагч тайланд буруу мэдээлэл оруулсан, орлогын талаар дутуу мэдээлсэн, эсхүл тайланг хуульд заасан хугацааны дотор тайлагнаагүй бол Засгийн газрын тайлан гаргагч энэхүү зөрчлийг яагаад гаргасан талаархи тодорхой мэдээллийг тусгана;

9.4.14. Засгийн газрын тайлан гаргагч болон олборлогч компанийн гаргасан тайлангууд нь олон улсын стандартын дагуу аудитаар шалгагдсан санхүүгийн тайланд тусгагдсан мэдээлэлд үндэслэсэн болохыг баталгаажуулах зорилгоор Сайд болон ажлын хэсгийн зүгээс авсан арга хэмжээнүүдийг дурьдана;

9.4.15. тайланг нэгтгэх явцын талаар нэгтгэгчийн зүгээс гарсан дүгнэлтийг оруулсан байна;

9.4.16. тайлангуудын хооронд гарсан аливаа зөрүүг илрүүлж тусгана;

9.4.17. тайлангуудын хооронд зөрүүг гарвал зөрүүг хэрхэн илрүүлэх тухай арга, аргачлалын талаархи танилцуулгыг тусгана;

9.4.18. тайлангуудын хооронд зөрүүг гарсан бол уг зөрүүг хэрхэн илрүүлсэн арга, аргачлалын тухай тусгана;

9.4.19. тайлангуудын хооронд гарсан зөрүүг хэрхэн арилгаж шийдвэрлэх, цаашид уг зөрүүг гаргуулахгүй байхад ямар арга хэмжээ авах тухай зөвлөмжийг тусгана;

9.4.20. тайлангуудын хооронд гарсан зөрүүний талаар Засгийн газрын тайлан гаргагч, олборлогч компанийн зүгээс ажлын албанд ирүүлсэн тайлбарын дагуу уг зөрүүг засах талаар нэгтгэгчээс ямар арга хэмжээ авсан талаар тусгасан байна.

9.5. Ажлын алба нь нэгтгэгчээс ирүүлсэн нэгдсэн дэлгэрэнгүй тайланг хүлээн авснаас хойш нэг сарын дотор ажлын хэсгийн хуралдаанаар хэлэлцүүлж, хуралдаанд оролцогчдын олонхи нэгдсэн дэлгэрэнгүй тайланг хангалттай гэж үзвэл ажлын хэсэгт уг тайланг батлуулахаар Үндэсний зөвлөлд санал оруулна.

9.6. Үндэсний зөвлөл ажлын хэсгээс оруулсан саналыг үндэслэн нэгдсэн дэлгэрэнгүй тайланг Үндэсний зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх ба Үндэсний зөвлөлийн хуралдаанд оролцогчдын олонхи нэгдсэн дэлгэрэнгүй тайланг хангалттай үзвэл тухайн хуралдаанаар уг тайланг батална.

9.7. Ажлын хэсэг, Үндэсний зөвлөлийн хуралдаанаас нэгдсэн дэлгэрэнгүй тайланг хангалтгүй гэж үзсэн тохиолдолд ажлын алба нэгдсэн дэлгэрэнгүй тайланг ажлын хэсэг буюу Үндэсний зөвлөлийн гишүүдийн гаргасан санал, шүүмжлэлийн дагуу нэмэлт өөрчлөлт хийлгэхээр нэгтгэгчид нэн даруй буцаана.

9.8. Нэгтгэгч нэгдсэн дэлгэрэнгүй тайлангийн талаар ажлын хэсэг буюу Үндэсний зөвлөлийн гишүүдийн гаргасан санал, шүүмжлэлийн дагуу нэмэлт өөрчлөлт оруулж нэгдсэн дэлгэрэнгүй тайланг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор ажлын албанд хүргүүлнэ. Ажлын алба нь нэмэлт өөрчлөлт оруулсан нэгдсэн дэлгэрэнгүй тайланг энэ зүйлд заасан журмын дагуу батлуулахаар ердийн журмаар ажлын хэсгээр, хэрэв Үндэсний зөвлөлөөс буцаасан бол шууд Үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулах ажлыг зохион байгуулна.

9.9. Ажлын алба Үндэсний зөвлөлөөс батлагдсан нэгдсэн дэлгэрэнгүй тайланг хэвлэн олшруулах, ажлын албаны цахим хуудсанд байршуулах зэргээр нийтийн хүртээл болгох ажлыг нэн даруй зохион байгуулна.

10 дугаар зүйл. Зөрүүг хянан шийдвэрлэх

10.1. Нэгдсэн дэлгэрэнгүй тайланг нэгтгэх явцад илэрсэн аливаа зөрүүг нэгтгэгч ажлын албанд нэн даруй мэдэгдэж, гарсан зөрүүний талаар Засгийн газрын тайлан гаргагч, олборлогч компаниас авах тайлбарын асуултын төслийг

бэлдэн ажлын албанд хүргүүлнэ. Ажлын алба нэгтгэгчээс ирүүлсэн саналын дагуу илэрсэн зөрүүний талаар тайлбар ирүүлэхийг Засгийн газрын тайлан гаргагч, олборлогч компанид тус тус албан бичиг явуулна. Засгийн газрын тайлан гаргагч, олборлогч компани нь уг зөрүүний талаархи дэлгэрэнгүй тайлбарыг 14 хоногийн дотор ажлын албанд гаргана.

10.2. Ажлын алба Засгийн газрын тайлан гаргагч, олборлогч компаниас ирүүлсэн тайлбарыг нэгтгэгчид нэн даруй хүргүүлэх бөгөөд нэгтгэгч талуудын ирүүлсэн тайлбаруудын талаархи дүгнэлт, гарсан зөрүүг хэрхэх талаар нэгдсэн дэлгэрэнгүй тайланд тусгахаас гадна тайлангуудыг нэгтгэх явцад гарсан зөрүү болгонд тус тусад нь дүгнэлт гаргаж дэлгэрэнгүй нэгдсэн тайлангийн хамт ажлын албанд хүргүүлнэ.

10.3. Ажлын хэсэг нэгтгэгчээс нэгдсэн дэлгэрэнгүй тайланг нэгтгэх явцад илэрсэн зөрүү болгонд гаргасан дүгнэлтийг хэлэлцэн Засгийн газрын тайлан гаргагч, олборлогч компани нь тайлан маягтын дагуу хэрхэн гаргах талаархи мэдлэг, мэдээлэл дутмагаас шалтгаалан тайланг дутуу буюу буруу гаргасан бол тайлангийн маягтыг хэрхэн зөв гаргах талаар сургалт, семинарыг зохион байгуулахыг ажлын албанд даалгана.

10.4. Засгийн газрын тайлан гаргагч, олборлогч компаниас тайланг санаатайгаар дутуу буюу буруу гаргасан бол энэ хуульд заасан хариуцлага оногдуулахаар Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт зөрчлийн талаар гомдол гаргах, эсхүл олборлогч компанийн тусгай зөвшөөрлийг цуцлуулах тухай саналыг ажлын албанаас боловсруулан Үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлэх тухай шийдвэрийг тус тус Ажлын хэсгийн хуралдаанаас гаргана.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

11 дүгээр зүйл. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хэрэгжүүлэх байгууллагын тогтолцоо

11.1. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хэрэгжүүлэх байгууллага нь Үндэсний зөвлөл, ажлын хэсэг, дэд зөвлөл, ажлын албанаас бүрдэнэ.

11.2. Үндэсний зөвлөл нь аймаг, нийслэл, сум, дүүрэгт Үндэсний зөвлөлийн чиг үүргийн биелэлтийг дэмжих зорилгоор дэд зөвлөлүүдийг байгуулж болно. Дэд зөвлөлийг байгуулах бол Үндэсний зөвлөл дэд зөвлөлийн бүрэлдэхүүн, орон тоог батална.

11.3. Үндэсний зөвлөлийн удирдлаган дор ажлын хэсэг, ажлын алба ажиллах бөгөөд Үндэсний зөвлөлийн хуралдаанаас ажлын албаны бүрэлдэхүүнийг баталж, ажлын албаны даргыг томилно.

11.4. Ажлын албаны дарга ажлын албаны ажилтан, дэд зөвлөлийн дарга, ажилтныг томилно.

12 дугаар зүйл. Үндэсний зөвлөл

12.1. Үндэсний зөвлөл нь олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хэрэгжүүлэх үндсэн зарчим болон улс төр, эрх зүй, зохион байгуулалтын нөхцлийг бүрдүүлэх, хянан зохицуулах эрх, үүрэг бүхий тасралтгүй үйл ажиллагаа явуулах бие даасан Засгийн газрын байгууллагын төлөөлөл, олборлогч компаниудын төлөөлөл, иргэний нийгмийн төлөөлөл бүхий зөвшлийн байгууллага байна.

12.2. Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд төрийн байгууллагын төлөөллийн 9 гишүүн, олборлогч компаниуд, мэргэжлийн холбоодын төлөөллийн 9 гишүүн, иргэний нийгмийн эвслийн төлөөллийн 9 гишүүн тус тус орох бөгөөд Үндэсний зөвлөлийн дарга нь Ерөнхий сайд, орлогч дарга нь олборлогч компани, мэргэжлийн холбоодын төлөөлөл, иргэний нийгмийн эвслийн төлөөллийн аль нэг 1 гишүүн, нарын бичгийн дарга нь төрийн нарийн бичгийн дарга байна. Үндэсний зөвлөлийн орлогч даргыг Үндэсний зөвлөлийн хурлаар нэг жилийн хугацаатайгаар олборлогч компани, мэргэжлийн холбоодын төлөөллөөс, эсхүл иргэний нийгмийн эвслийн төлөөллөөс жил бүр ээлжлэн сонгоно.

12.3 Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг талуудын санал болгосноор 3 жилийн хугацаагаар дараахь байдлаар Ерөнхийлөгчийн зарлигаар батална. Үүнд:

12.3.1. Үндэсний зөвлөлд орох төрийн байгууллагын төлөөллийн гишүүнийг Ерөнхий сайдаас санал болгосноор;

12.3.2. Үндэсний зөвлөлд орох олборлогч компани, мэргэжлийн холбоодын төлөөллийн гишүүнийг Монголын уул уурхайн ассоциацийн удирдах байгууллагаас санал болгосноор;

12.3.3. Үндэсний зөвлөлд орох иргэний нийгмийн эвслийн төлөөллийн гишүүнийг иргэний нийгмийн эвслийн удирдах байгууллагын хурлаас санал болгосноор.

12.4. Үндэсний зөвлөлийн гишүүн хугацаанаасаа өмнө Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнээс чөлөөлөгдөх тухай хүсэлтээ Ерөнхийлөгчид бичгээр мэдэгдэж, Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнээс гарч болно.

12.5. Үндэсний зөвлөлийн гишүүнийг хугацаанаас нь өмнө дараахь тохиолдолд Ерөнхийлөгчийн зарлигаар чөлөөлж болох бөгөөд бусад нөхцөлд чөлөөлж болохгүй:

12.5.1. эрүүл мэндийн хувьд гишүүний үүргийг гүйцэтгэх боломжгүй болох;

12.5.2. Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд орохоосоо өмнө төрийн байгууллага болон олборлогч компанид ажиллаж байсан албан тушаалд ажиллахгүй болсон, мэргэжлийн холбоо, иргэний нийгмийн эвслээс гарсан бол;

12.2.3 Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн даргаас хүндэтгэн үзэх шалтгааны улмаас урьдчилан чөлөө авалгүйгээр Үндэсний зөвлөлийн хуралд 3 удаа дараалан оролцоогүй бол.

12.6. Үндэсний зөвлөлийн гишүүний сул орон тоо гарсан тохиолдолд сул орон гарсан төлөөллийн эрх бүхий байгууллага, албан тушаалтан нэн даруй Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн дэх өөрийн төлөөллийн шинэ гишүүнийг 3 жилийн хугацаатай томилуулахаар Ерөнхийлөгчид санал оруулна.

12.7. Энэ хуульд зааснаас бусад байдлаар аливаа этгээд Үндэсний зөвлөлийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлөх, саад учруулахыг хориглоно.

13 дугаар зүйл. Үндэсний зөвлөлийн үйл ажиллагаа

13.1. Үндэсний зөвлөлийн үндсэн үйл ажиллагааны хэлбэр нь хуралдаан байх бөгөөд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

13.1.1. энэ хуулиар Үндэсний зөвлөлд олгосон эрх, үүргийг хэрэгжүүлэх;

13.1.2. дэлгэрэнгүй нэгдсэн тайлан болон бусад мэдээллийг харуулах цахим хуудас бий болгох, ажлын хэсгийн ахлагч, нарийн бичгийн дарга, оролцогч талуудын төлөөллийн ахлагчдын нэр, хаягийг цахим хуудсаар нийтэд ил болгох;

13.1.3. олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын хэрэгжилтийг боловсруулалт, хэрэгжилт, хяналт шинжилгээ болон үнэлгээний явцад иргэний нийгмийн эвсэл болон олборлогч компаниудтай тогтвортой харилцаатай байх нөхцлийг бүрдүүлэх;

13.1.4. олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын хэрэгжилт, ил тод байдал болон байгалийн баялгийг талаарх олон нийтийн хэлэлцүүлгийг дэмжих;

13.1.5. иргэний нийгмийн эвсэл болон олборлогч компаниуд хоорондын харилцааг дэмжих;

13.1.6. энэ хуулийн ач холбогдол, нэгдсэн дэлгэрэнгүй тайланг нийтийн хүртээл болгох ажлыг зохион байгуулах;

13.1.7. олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тогтвортой хэрэгжилтийг хангах.

13.2. Үндэсний зөвлөл нь энэхүү хуулийн зорилгын хүрээнд өөрийн үйл ажиллагааг явуулахад шаардлагатай аливаа арга хэмжээнүүдийг авах бүрэн эрхтэй.

13.3. Үндэсний зөвлөл нь олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар эрдэмтэн, мэргэжилтэн, зөвлөх оролцсон шинжээчийн хэсэг байгуулж дүгнэлт гаргуулж болно.

14 дүгээр зүйл. Үндэсний зөвлөлөөс тавих хяналт

14.1. Үндэсний зөвлөл гаргасан шийдвэр, өгсөн үүргийн биелэлтээ гаргуулж гишүүдэд танилцуулах, шаардлагатай бол хуралдаанаар хэлэлцэх бөгөөд хуралдааны чөлөө цагт Үндэсний зөвлөлийн дарга танилцаж чиглэл өгнө.

14.2. Үндэсний зөвлөлийн гаргасан шийдвэрийн биелэлт, олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хэрэгжүүлж байгаа байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд гишүүд, ажлын хэсэг хяналт тавина.

14.3. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хэрэгжүүлэх чиглэлээр ажлын хэсгээс хийж байгаа үйл ажиллагааны явц, биелэлттэй Үндэсний зөвлөлийн дарга, гишүүд танилцаж, явцыг эрчимжүүлэх арга хэмжээ авч болно.

14.4. Үндэсний зөвлөл жил бүр тайлан гаргаж Ерөнхийлөгчид танилцуулах ба ажлын албаны цахим хуудсанд байрлуулна.

15 дугаар зүйл. Үндэсний зөвлөлийн хуралдаан

15.1. Үндэсний зөвлөлийн ээлжит хуралдаан жилд нэгээс доошгүй хуралдах ба хуралдааныг Үндэсний зөвлөлийн дарга даргална. Үндэсний зөвлөлийн даргыг эзгүйд Үндэсний зөвлөлийн даргын даалгаснаар үндэсний зөвлөлийн аль нэг гишүүн үндэсний зөвлөлийн хуралдааныг удирдан явуулах, хуралдааны чөлөөт цагт үндэсний зөвлөлийн ажлыг зохицуулна.

15.2 Үндэсний зөвлөлийн хуралдаанаар дараахь асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ:

15.2.1 олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын талаарх хууль тогтоомж, шийдвэрийн төслийг боловсруулах чиглэлийг өгөх асуудал;

15.2.2. олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан ажлын хэсгээс боловсруулсан төслүүд;

15.2.3. олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан төрийн байгууллагын удирдлагын мэдээлэл, санал;

15.2.4. Үндэсний зөвлөлийн ажиллах журам, ажлын албаны дүрэм, ажлын хэсгийн тайлан, мэдээлэл;

15.2.5. Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааний төлөвлөгөө, тайлан, дэлгэрэнгүй нэгдсэн тайлан;

15.2.6. хуралдаанаар хэлэлцэх шаардлагатай гэж үзсэн бусад асуудал.

15.3. Үндэсний зөвлөл шаардлагатай үед Үндэсний зөвлөлийн даргын, эзгүйд орлож байгаа гишүүний зарласнаар хуралдана. Хуралдааны бэлтгэлийг Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга хангана..

15.4. Үндэсний зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг Үндэсний зөвлөлийн дарга, түүний эзгүйд орлож байгаа гишүүнд танилцуулж хуралдаанаас 2-оос доошгүй хоногийн өмнө гишүүдэд цахим шуудангаар хүргүүлнэ.

15.5. Үндэсний зөвлөлийн хуралдаан гишүүдийн олонхи бүрдсэнээр эхэлнэ. Үндэсний зөвлөлийн дарга, түүний эзгүйд орлож байгаа гишүүний зөвшөөрснөөр гишүүн саналаа бичгээр ирүүлж болно.

15.6. Үндэсний зөвлөлийн гишүүн хуралдаанд асуудал боловсруулан хэлэлцүүлэх, хэлэлцэх асуудлын талаар санал гаргах эрхтэй. Гишүүн хуралдаанаар хэлэлцүүлэхээр боловсруулсан асуудлаа Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн даргад өгч хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулж гишүүдэд хүргүүлнэ.

15.7. Үндэсний зөвлөлийн хурлын үеэр гарах аливаа асуудлыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.

15.8. Үндэсний зөвлөл хуралдааны тэмдэглэл гаргана. Үндэсний зөвлөлийн хуралдааны тэмдэглэлийг ажлын албаны ажилтан хөтөлнө. Тэмдэглэлд Үндэсний зөвлөлийн хуралдаан даргалагч, нарийн бичгийн дарга гарын үсэг зурж албажуулна.

16 дугаар зүйл. Ажлын хэсэг

16.1. Ажлын хэсэг нь олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хэрэгжүүлэх эрх, үүрэг бүхий олон талын оролцоог хангасан төрийн байгууллагын төлөөлөл, олборлогч компаниудын төлөөлөл, иргэний нийгмийн төлөөлөл гэсэн 3 талын адил тэгш төлөөллөөс бүрдэнэ.

16.2. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Засгийн газрын байгууллагын төлөөллийн 10 гишүүн, олборлогч компани, мэргэжлийн холбоодын төлөөллийн 10 гишүүн, иргэний нийгмийн эвслийн төлөөллийн 10 гишүүн тус тус орох бөгөөд ажлын хэсгийн бүрэлдэхүүний төлөөллийг дараахь байдлаар томилж, чөлөөлнө. Үүнд:

16.2.1. ажлын хэсэгт орох төрийн байгууллагын төлөөллийг Ерөнхий сайд 3 жилийн хугацаагаар томилж чөлөөлнө;

16.2.2. ажлын хэсэгт орох олборлогч компани, мэргэжлийн холбоодын төлөөллийг **Монголын уул уурхайн ассоциацийн** удирдах байгууллагаас 3 жилийн хугацаагаар томилж, чөлөөлнө.

16.2.3. ажлын хэсэгт орох иргэний нийгмийн эвслийн төлөөллийг иргэний нийгмийн эвслийн удирдах байгууллагын хурлаар хэлэлцэн 3 жилийн хугацаагаар томилж, чөлөөлнө.

16.3. Ажлын хэсгийн ахлагч нь Ерөнхий сайдын ахлах зөвлөх байх бөгөөд ажлын хэсгийн нарын бичгийн дарга нь ажлын албаны дарга байна. Ажлын хэсгийн ахлагчийн түр эзгүйд түүний даалгаснаар ажлын хэсгийн гишүүн ажлыг нь орлоно.

16.4. Оролцогч талууд өөрийн төлөөллийн ахлагчийг ажлын хэсгийн гишүүд дундаасаа сонгоно.

16.5. Оролцогч талуудын төлөөлөл өөрчлөгдсөн тохиолдолд чөлөөлөгдсөн гишүүн, шинээр томилогдсон гишүүний талаархи мэдээллийг чөлөөлсөн, томилсон эрх бүхий байгууллага, албан тушаалтан ажлын хэсгийн нарын бичгийн даргад мэдэгдэнэ.

16.6. Ажлын хэсгийн гишүүн хугацаанаасаа ажлын хэсгийн бүрэлдэхүүнээс чөлөөлөгдөх тухай хүсэлтээ томилсон байгууллага, албан тушаалтанд өгч, ажлын хэсгийн бүрэлдэхүүнээс гарч болно. Ажлын хэсгийн гишүүн өөрийн хүсэлтээр ажлын хэсгийн бүрэлдэхүүнээс гарах бол энэ тухай ажлын хэсгийн нарын бичгийн даргад мэдэгдэнэ.

16.7. Ажлын хэсгийн гишүүнийг хугацаанаас нь өмнө дараахь тохиолдолд чөлөөлж болох бөгөөд бусад нөхцөлд чөлөөлж болохгүй:

16.7.1. эрүүл мэндийн хувьд гишүүний үүргийг гүйцэтгэх боломжгүй болох;

16.7.2. ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орохоосоо өмнө Засгийн газрын байгууллага болон олборлогч компанид ажиллаж байсан албан тушаалд ажиллахгүй болсон, мэргэжлийн холбоо, иргэний нийгмийн эвслээс гарсан бол;

16.7.3 ажлын хэсгийн нарийн бичгийн даргаас хүндэтгэн үзэх шалтгааны улмаас урьдчилан чөлөө авалгүйгээр ажлын хэсгийн хуралд 3 удаа дараалан оролцоогүй бол.

16.8. Ажлын хэсгийн гишүүний сул орон тоо гарсан тохиолдолд эрх бүхий байгууллага, албан тушаалтан нэн даруй орон гарсан гишүүнийг 3 жилийн хугацаагаар томилно.

17 дугаар зүйл. Ажлын хэсгийн чиг үүрэг

17.1. Ажлын хэсэг нь дор дурьдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ:

17.1.1. энэ хуулиар ажлын хэсэгт олгосон эрх, үүргийг гүйцэтгэх;

17.1.2. олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын хэрэгжилтэнд хяналт тавих;

17.1.3. олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын талаарх олон нийтийн хэлэлцүүлэгт хувь нэмэр оруулах;

17.1.4. иргэд, иргэний нийгмийн эвсэл болон олборлогч компанитай хамтран ажиллах тухай санал, мэдээлэл хүргүүлэхдээ хэвлэл мэдээлэл, цахим хуудас, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, захиа зэрэг хамгийн үр дүнтэй харилцааны аргуудыг дараах байдлаар ашиглах:

а/ Засгийн газрын зүгээс олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагыг дэмжиж хэрэгжүүлэх хүсэл эрмэлзэлтэй байгаа талаар, мөн олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын хэрэгжилтийн явцад иргэд, иргэний нийгмийн эвсэл болон олборлогч компани голлох үүрэг гүйцэтгэх талаар иргэд, иргэний нийгмийн эвсэл болон олборлогч компанид мэдээлэл хүргэх;

б/ олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын хэрэгжилт, нэгдсэн дэлгэрэнгүй тайлангаар гарсан үр дүнг олон нийтэд мэдээлэх.

17.1.5. олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хэрэгжүүлэх сургалт, семинарыг зохион байгуулах арга хэмжээ авах;

17.1.6. олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хэрэгжүүлэхтэй холбоотой аливаа асуудлыг ажлын хэсэг эхлэн боловсруулж ажлын хэсгийн хуралдаанаар хэлэлцэн Үндэсний зөвлөлд танилцуулж байх.

17.1.7. олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын хэрэгжилт тогтвортой хэрэгжих нөхцлийг хангах.

17.2. Ажлын хэсэг нь энэхүү хуулийн зорилгын хүрээнд өөрийн үйл ажиллагааг явуулахад шаардлагатай бүх арга хэмжээ авах бүрэн эрхтэй.

18 дугаар зүйл. Ажлын хэсгийн үйл ажиллагаа

18.1. Ажлын хэсэг нь өөрийн эрх хэмжээний хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

18.1.1. ажлын хэсгийн гишүүдийн оролцоог бүрэн хангасан дотоод засаглалаа хэрэгжүүлэх дүрэм, журмыг батлан гаргах;

18.1.2. энэ хуульд заасан олборлогч компаниас төлсөн төлбөр ба төрийн байгууллагын хүлээн авсан орлогыг тодорхойлох;

18.1.3. нэгтгэгчийн үүрэг гүйцэтгэх этгээдээс нэгдсэн дэлгэрэнгүй тайлан гаргах удирдамжийг батлах;

18.1.4. ажлын хэсгийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах, нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэх.

18.2. Ажлын хэсэг нь төрийн байгууллага, иргэний нийгмийн эвсэл болон олборлогч компаниудтай зөвшилцсөний үндсэн дээр ажлын төлөвлөгөөний дагуу хийгдэх зардлыг батална.

18.3. Ажлын хэсгийн ажлын төлөвлөгөөнд дор дурьдсан ажлууд орно:

18.3.1. олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын хэрэгжилтийг үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор дэвшүүлсэн зорилт, хэрэгжих хугацаа, биелэлтийг хянах арга, эдгээр ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай арга хэмжээнүүдийг тодорхойлсон байна;

18.3.2. олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын хэрэгжилтийг үр дүнтэй болгоход саад учруулж болох төрийн байгууллага, иргэний нийгмийн эвсэл болон олборлогч компаниудын чадавхийн дутагдалыг үнэлж, эдгээр дутагдлыг сургалт, семинар явуулах зэргээр засах арга хэмжээнүүдийг дурьдана;

18.3.3. үйл ажиллагаа явуулж буй бүх олборлогч компаниудын жагсаалтыг гаргана.

18.4. Ажлын хэсэг ажлын төлөвлөгөөгөө ажлын албаны цахим хуудаст байрлуулна.

18.5. Ажлын хэсэг ажлын төлөвлөгөөний хэрэлжилтэнд тогтмол хянаж, шаардлагатай нэмэлт өөрчлөлтийг оруулна.

19 дүгээр зүйл. Ажлын хэсгийн хуралдаан

19.1. Ажлын хэсгийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна. Ажлын хэсгийн ээлжит хуралдаан жилд дөрвөөс доошгүй удаа хуралдах ба ажлын хэсгийн аль нэг талын төлөөлөл, эсхүл 10 буюу түүнээс дээш тооны гишүүдээс бичгээр ажлын хэсгийн хуралдаан хийх, хэлэлцэх асуудлын санал гаргавал ажлын хэсгийн ахлагч хуралдааныг нэн даруй зарлан хуралдуулна.

19.2. Ажлын хэсгийн 3 талын төлөөллийн ахлагч, гишүүд тодорхой сэдвээр мэргэшин хуралдаанаар хэлэлцэх асуудлыг урьдчилан бэлтгэж, ажлын хэсгийн ахлагч, нарийн бичгийн дарга нарт дэмжлэг үзүүлнэ.

19.3. Ажлын хэсэг нь ажлын хэсгийн ахлагч, түүний эзгүйд орлож байгаа гишүүн зарласнаар хуралдана. Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга нь хуралдаанаар хэлэлцэх асуудал, хуралдааны товыг ажлын хэсгийн ахлагч, түүний эзгүйд орлож байгаа гишүүнтэй зөвлөлдөн, улмаар талуудын төлөөллийн ахлагчид танилцуулж, гишүүдэд зарлан, хуралдаанаар хэлэлцэх материалыг 3-аас доошгүй хоногийн өмнө ажлын хэсгийн гишүүдэд хүргүүлнэ.

19.5. Оролцогч талын төлөөллийн ахлагч, гишүүд хуралдаанаар хэлэлцүүлэхээр боловсруулсан асуудлаа ажлын хэсгийн нарийн бичгийн даргад бичгээр болон цахим хэлбэрээр өгч хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулахаар уламжилна.

19.6. Гишүүдийн боловсруулсан баримт бичгийн төслийг ажлын хэсгийн нарийн бичгийн дарга хүлээн авч хуралдаанд хэлэлцүүлэх бэлтгэлийг хангана.

19.7. Ажлын хэсгийн хуралдаан гишүүдийн олонхи бүрдсэнээр хүчин төгөлдөр байна. Бичгээр саналаа ирүүлсэн гишүүнийг ирсэнд тооцох бөгөөд саналыг төлөөллийн ахлагч хуралдаанд оролцогчдод уншиж сонгоно.

19.8. Ажлын хэсгийн гишүүн ажлын хэсгийн хуралдаанд биечлэн оролцох боломжгүй бол өөрийнхөө оронд өөр хүнийг томилж хуралдаанд оролцуулж болно.

19.9. Ажлын хэсгийн ахлагч хуралдаанд хүрэлцэн ирээгүй тохиолдолд хуралдаанд ирсэн гишүүд дотроосоо хуралдааныг даргалах хүнийг сонгоно.

19.10. Ажлын хэсгийн хуралдаанаар дараахь асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ:

19.10.1. олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хэрэгжүүлэх талаархи бодлого, төлөвлөгөө, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудал;

19.10.2. олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан оролцогч талууд, ажлын хэсгийн гишүүдээс боловсруулсан төсөл, танилцуулга, үнэлэлт, дүгнэлт;

19.10.3. Монгол Улсын олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хэрэгжүүлэх талаархи ажлын төлөвлөгөө, тухайн жилийн урьдчилсан болон эцсийн тайлан, түүнтэй холбоотой судалгаа, дүгнэлт, баталгаажуултын асуудал;

19.10.4. олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлж байгаа ажлын явц, үр дүнгийн талаар төрийн холбогдох байгууллагын удирдлагын санал, мэдээлэл, танилцуулга;

19.10.5. ажлын хэсгийн ажиллах журам, тайлан;

19.10.6. ажлын албаны тайлан, мэдээлэл;

19.10.7. нэгтгэгчээс ирүүлсэн дэлгэрэнгүй нэгдсэн тайлан;

19.10.8. энэ хууль болон бусад хууль тогтоомжоор ажлын хэсгийн ажил үүрэгт хамаарах бусад асуудал.

19.11. Ажлын хэсгийн хуралдаанд дотоод, гадаадын аль ч байгууллага, албан тушаалтан, иргэн оролцох, үг хэлэх, санал гаргах, асуулт асууж, хариулт авах нь нээлттэй.

19.12. Ажлын хэсгийн хуралдааны үеэр гарах аливаа асуудлыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.

19.13. Ажлын хэсгийн хуралдааны үеэр хэлэлцэх асуудалд хамааралтай ашиг сонирхлын зөрчилтэй гишүүн энэ тухай мэдэгдэх ёстой бөгөөд хуралдааны санал хураалтанд саналын эрхтэй оролцохгүй.

19.14. Ажлын хэсгийн хуралдаанаас тэмдэглэл гаргана. Тэмдэглэл нь дэлгэрэнгүй, хураангуй гэсэн 2 хэлбэртэй байна. Ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэлийг ажлын албаны ажилтан хөтөлнө. Тэмдэглэлд ажилтан, ажлын хэсгийн ахлагч гарын үсэг зурж албажуулна.

19.15. Ажлын хэсгийн хуралдааныг оролцогч талуудын байранд ээлжлэн хийх бөгөөд хуралдаан зохиогдож байгаа байгууллагын удирдлага тухайн байгууллагын үйл ажиллагаатай гишүүдийг танилцуулна.

19.16. Ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэл, хэлэлцсэн асуудлыг ажлын албаны цахим хуудас болон хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчилна. Энэ зорилгоор ажлын хэсгийн хуралд хэвлэл мэдээллийн ажилтан, сурвалжлагчийг урьж оролцуулж болно.

19.17. Ажлын хэсгийн хуралдааныг цахим хэлбэрээр хийх шийдвэрийг ажлын хэсгийн ахлагч, эсхүл түүний даалгаснаар ажлын хэсгийн нарийн бичгийн дарга төлөөллийн ахлагч нартай зөвшилцөн гаргана. Цахим хурлын хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төслийг гишүүдэд цахим шуудангаар хариу авах хугацааг тодорхой заан хүргүүлж, шийдвэрийн төсөлд авсан саналыг ажлын 2 хоногт тусган гишүүдэд эргэн мэдээлж, улмаар Оролцогч талуудын төлөөллийн ахлагчтай зөвшилцөн эцсийн шийдвэрийг тэмдэглэл хэлбэрээр гаргана. Тэмдэглэлийг ажлын хэсгийн ахлагч, нарийн бичгийн дарга нар гарын үсэг зурж албажуулна.

19.18. Ажлын хэсгийн хуралдааны материалыг архивын журмын дагуу бүрдүүлж архивын нэгж болгон хадгална. Мөн цахим хурлын материалыг иж бүрдүүлж архивын нэгж болгоно.

20 дугаар зүйл. Ажлын алба

20.1. Ажлын алба нь **ажлын хэсгийн ахлагчийн** удирдлага, зохицуулалтын дор ажиллах бөгөөд олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хэрэгжүүлэхтэй холбоотой аливаа асуудлыг мэргэшин хариуцах, Үндэсний зөвлөл, ажлын хэсгийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтийг гаргаж тайлагнах бөгөөд олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хэрэгжүүлэхтэй холбогдсон өдөр тутмын үйл ажиллагааг эрхэлнэ.

20.2. Ажлын алба нь олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хэрэгжүүлэх чиглэлээр Үндэсний зөвлөл, ажлын хэсгээс гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх, чадавхи бэхжүүлэх сургалт, семинар, зөвлөлгөөн зохион байгуулах бүхий л үйл ажиллагааг эрхэлнэ.

20.3. Ажлын алба нь олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг Монгол Улсад хэрэгжүүлж байгаа бодлого, шийдвэр, тэдгээрийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаар мэдээлж байх цахим хуудсыг ажиллуулна.

20.4. Ажлын алба энэ хууль болон ажлын албаны дүрэмд заасан үйл ажиллагааг явуулах бөгөөд ажлын албаны ажиллах дүрмийг Үндэсний зөвлөл батална.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ БУСАД

21 дүгээр зүйл. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хэрэгжүүлэх байгууллагын санхүүжилт

21.1. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хэрэгжүүлэх байгууллагын санхүүжилтыг улсын төсвөөс гаргана.

21.2. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хэрэгжүүлэх байгууллагын санхүүжилт Үндэсний зөвлөл, ажлын хэсгийн бие даасан, хараат бус үйл ажиллагааг хангахад чигдэгдсэн байна.

21.3. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хэрэгжүүлэх байгууллагын жилийн төсвийн хэмжээ нь өмнөх жилүүдийн төсвийн хэмжээнээс багагүй байх ёстой.

21.4. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хэрэгжүүлэх байгууллага нь гадаад улс, олон улсын байгууллага, Монгол Улсын болон гадаад улсын аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус байгууллага, иргэдээс олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын хэрэгжилтийг дэмжиж өгсөн зээл, хандив, тусламжаар санхүүжиж болно.

22 дугаар бүлэг. Хууль тогтоомжинд зөрчигчид хүлээлгэх хариуцлага

22.1. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хууль тогтоомж зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол эрх бүхий байгууллага, албан тушаалтан зөрчлийн шинж байдлыг харгалзан гэм буруутай этгээдэд дараахь хариуцлага хүлээлгэнэ:

22.1.1. олборлогч компани энэ хуулийн 7 дугаар зүйлд заасныг зөрчиж Засгийн газрын тайлан гаргагчт төлсөн нийт төлбөрийн дэлгэрэнгүй тайланд санаатайгаар худал мэдээлэл оруулан буруу, дутуу тайлагнасан, эсхүл тайланг хуульд заасан хугацааны дотор ажлын албанд хүргүүлээгүй бол улсын байцаагч олборлогч компанийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 30 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл олборлогч компанийн эзэмшиж буй тусгай зөвшөөрлийг **Үндэсний зөвлөлийн** саналыг үндэслэн тусгай зөвшөөрөл олгосон төрийн захиргааны байгууллага цуцлана.

22.1.2. төрийн байгууллага, Засгийн газрын тайлан гаргагч энэ хуулийн 8 дугаар зүйлд заасныг зөрчиж Засгийн газрын тайлан гаргагчт төлсөн нийт төлбөрийн дэлгэрэнгүй тайланд санаатайгаар худал мэдээлэл оруулсан, тайланг санаатайгаар буруу, дутуу тайлагнасан, эсхүл тайланг хуульд заасан хугацааны дотор ажлын албанд хүргүүлээгүй бол гэм буруутай албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

22.1.3. нэгтгэгч энэ хуулийн 9 дугаар зүйлд заасныг зөрчиж хуульд заасан хугацааны дотор нэгдсэн дэлгэрэнгүй тайлан, нэмэлт өөрчлөлтийг ажлын албанд хүргүүлээгүй, тайланд санаатайгаар худал мэдээлэл оруулан буруу, дутуу тайлагнасан бол нэгтгэгчийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

22.1.4. ажлын алба энэ хуулийн 9 дугаар зүйлд заасныг зөрчиж хуульд заасан хугацааны дотор Засгийн газрын тайлан гаргагч, олборлогч компаниас ирүүлсэн орлого, төлбөрийн талаархи тайлан, нэмэлт өөрчлөлт хийлгэхээр буцаасан нэгдсэн дэлгэрэнгүй тайланг нэгтгэгчид хүргүүлээгүй, эсхүл энэ зүйлд заасан хугацааны дотор нэгдсэн дэлгэрэнгүй тайланг ажлын алба, Үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулаагүй бол гэм буруутай албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2013 оны ... сарын ... өдөр

Улаанбаатар хот

АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Ашигт малтмалын тухай хуулийн 56 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй:

56.1.6. тусгай зөвшөөрөл эзэмшигч Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан тайлан гаргахдаа уг тайланд санаатайгаар худал мэдээлэл оруулан буруу, дутуу тайлагнасан талаар Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хэрэгжүүлэх Үндэсний зөвлөлөөс тусгай зөвшөөрлийг цуцлах санал гаргасан.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийг хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2013 оны ... сарын ... өдөр

Улаанбаатар хот

ЦӨМИЙН ЭНЕРГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Цөмийн энергийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2.2-ын "56.1.3-56.1.5" гэснийг "56.1.3-56.1.6" гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийг хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ